



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 15 дугаар зүйлийн 15.12.2, 15.12.3, 15.12.4, 15.12.11, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллагуудын нэрсийг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах байгууллагуудын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.


3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 01 сарын 16-ны өдрийн
АБ7 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



**ЭРҮҮЛ МЭНД, ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	"МШББ" ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
2	"Хаппи инвест" ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
3	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ (амбулатори)	3 жил

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 01 сарын 16-ны өдрийн
А/27 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



**ЭРҮҮЛ МЭНД, ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	Энто ХХК	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм импортлох, ханган нийлүүлэх	3 жил
2	Еврофарм ХХК	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм импортлох, ханган нийлүүлэх	3 жил
3	Чинбаян ХХК	Эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
4	Монгол эм импекс концерн ХХК	Вакцин импортлох, ханган нийлүүлэх	3 жил
5	Нонаба ХХК Мөнхийн үйлс- 2 эмнэлэг	Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ	3 жил